

# Статистикийн хэлтэс

..... танаа



**Төв аймгийн хүн ам, өрхийн  
үндсэн үзүүлэлтийн төлөв  
байдал**

**(2009 оноор)**

Зуунмод

2010 он

## ГАРЧИГ

- I. Товч тайлбар, тодорхойлолт.
- II. Хүн ам, нийгмийн тайлангуудын танилцуулга.
- III. Судалгаа.

**III.1. Суурин хүн амын динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.**

**III.2. Хүн амын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.**

**III.3. Сумдын суурин хүн ам 1994 оныг 2009 онтой харьцуулсан үзүүлэлтийн тооцоолол.**

**III.4. Динамик хандлагын шинжилгээ.**

**III.5. Цикл хэлбэлзэлийн шинжилгээ.**

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

## ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн хүн ам, өрхийн тоо болон нийгмийн зарим үзүүлэлтүүдийг ХА-3, НС-1 мэдээ, тайланг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дүнг нэгтгэн 2009 оны 1 дүгээр сард гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн болно.

2009 оны дүнд үндэслэсэн энэхүү танилцуулгад хүн ам, өрхийн тоо, түүний байршил, нийгэм ахуйн зарим үзүүлэлтүүд зэрэг үзүүлэлтүүдийг 2-10 жилийн гүйцэтгэлээр зэрэгцүүлэлт хийж харуулсан.

Танилцуулга нь 4 бүлэг, 41 хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд дүнг бүсчилсэн байдлаар Төв, Хойд, Баруун, Зүүн бүс гэсэн ангиллаар зэрэгцүүлэлт хийн гаргалаа.

Аймгийн хүн амын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

## СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2010 он.

## I. ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Суурин хүн ам**=тухайн сум, дүүргийн (баг, хорооны) нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүн ам+оны эцэст сум, дүүргийн (баг, хорооны) нутаг дэвсгэрт байхгүй боловч 6 сарын дотор орон нутагтаа эргэж ирэх түр эзгүй хүн. Оны эхний хүн ам+(төрсөн хүүхдийн тоо-нас барсан хүний тоо)+(шилжиж ирсэн хүний тоо-шилжиж явсан хүний тоо)=оны эцсийн хүн амын тоо

**Өрх-ураг** төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ.

**Нэг өрхөд ногдох хүний тоо.** Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тооллогдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.

**Хүн амын байршил:** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулинд: **Хот**-гэдэгт 15000-аас доошгүй оршин суугчидтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг;

**Тосгон** гэдэгт: 500-15000 хүртэл оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, тээвэр, аялал жуучлал, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн өөрийн удирдлага бүхий суурин газрыг ;

**Хүйсийн харьцаа:** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

**Хүн ам зүйн ачаалал:** Хүн ам зүйн ачаалал гэсэн үзүүлэлт нь 0-14 насны болон 65, түүнээс дээш настай хүн амын тоог 15-64 насны хүн амын тоонд харьцуулсан харьцааг илэрхийлдэг

Б. Хүн амын ердийн хөдөлгөөн:

**Төрөлтийн ерөнхий коэффициент.** Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж тооцдог.

**Төрөлтийн тусгай коэффициент:** Төрөх насны буюу ( 15-49 насны ) 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент: Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцааг хэлнэ.

**Нас баралтын ерөнхий коэффициент:** Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

**Насны бүлэг дэх нас баралтын коэффициент:**Тухайн насны бүлэгт нас барсан

хүний тоог мөн насны бүлгийн хүн амд харьцуулсан харьцаа юм.

**Нялхасын нас баралтын** коэффициент: Нэг хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулсан харьцаагаар илэрхийлдэг үзүүлэлт юм.

**Гэрлэлтийн ерөнхий** коэффициент: Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “Батлуулсан гэр бүлтэй” буюу гэр бүлтэй гэнэ.

**Шилжилт хөдөлгөөн:** “Иргэний бүртгэлийн тухай” Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан журманд “Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ”

26 дугаар зүйлд “Иргэнийг аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар эрхэлнэ. Иргэнийг аймаг, нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, мэдээлэх ажлыг хариуцна” гэж тус тус заажээ.

**Бүтэн өнчин хүүхэд**-гэдэгт эцэг, эх нь хоёул нас барсан, хагас өнчин хүүхэд гэдэгт эцэг, эхийн аль нэг нь нас барсан хүүхдийг бүртгэнэ.

Бутагч хүүхэд болон гэр бүл салалтаас болж, эцэг, эхийнхээ аль нэгэнтэй нь амьдарч байгаа эцэг, эх нь энх тунх байгаа хүүхдүүдийг өнчин гэж үзэхгүй юм.

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ” “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ”

**16 хүртэл настай хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоо**-эцэг эх, хамаатан садангийн алинтай нь хамт амьдардгийг харгалзахгүйгээр бүгдийг хамруулна (эрэгтэй, эмэгтэй)

**Өрх толгойлсон хүний тоо:** Гэр бүлгүй өрхийн тэргүүлэгчдийн тоог хүйсээр ялгаж гаргана.

**Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн**-тоонд хүүхэдтэй эсэхийг үл харгалзан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг;

**Эрэгтэй тэргүүлэгчтэй** өрхөд гэр бүлгүй, өрхөө толгойлон амьдарч байгаа эрэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг үл харгалзан хамруулна.

“Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд “Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараахь хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ”

Энэ хуулийн 4 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай” Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлд “...Тахир дутууг тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тахир дутууг тогтооно...”

Өрхийн зарим үзүүлэлт: Нийт өрхөөс 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүдийг тусгайлан гаргасан. Мөн өндөр настай ганц бие амьдарч байгаа 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэйг тусгайлан, Нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэг тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоог гаргахдаа эрэгтэй 60 ба түүнээс дээш насныхныг, эмэгтэйг 55 ба түүнээс дээш насныхныг хамруулан гаргасан.

Эдийн засгийн бүсэд:

Төвийн бүс - Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Сэргэлэн, Зуунмод .

Хойд бүс - Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр.

Зүүн бүс - Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ.

Баруун бүс - Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант.

## **II. Хүн ам, өрх, нийгмийн 2009 оны жилийн эцсийн тайлангуудын дүнд хийсэн товч танилцуулга**

Аймгийн хүн амын тоо 2009 оны эцэст суурин хүнээр тооцсоноор 87210 хүн болж нийт хүний 50.29 хувь буюу 43.8 мянга нь эрэгтэйчүүд, 49,71 хувь буюу 43.3 мянга нь эмэгтэйчүүд болж, хүйсийн харьцаа 100 эмэгтэйд 101,1 эрэгтэй ногдлоо. Суурин хүн амын тоо 2008 оны эцсээс 1.89 хувь буюу 1.7 хүнээр буурлаа. 2009 оны эцсийн хүн амыг 1994 онтой харьцуулахад жилд дунджаар хүн амын тоо -1,19 %-иар буурчээ. Нийт хүн амын 51.43 хувь буюу 44.8 мянга нь аймаг, сумын төв, сууринд 48.57 хувь буюу 42.3 мянган нь хөдөөд амьдарч, төв сууринд суугчдын тоо 11.1 хувь буюу 5.6 мянгаар буурч, хөдөөд амьдардаг хүмүүсийн тоо 10.08 хувь буюу 3.9 мянгаар өссөн нь хөдөөд шилжин суурьшигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

2009 онд Улаанбаатар, Дархан, Орхон, Говь-сүмбэр болон бусад аймгаас 2793 хүн шилжин ирж, манай аймгаас 3247 хүн хот, бусад аймгуудад шилжин явж, шилжигсэдийн 75.3 хувь нь Улаанбаатар хотод шилжжээ.

2009 онд 2153 эх төрж 2170 хүүхэд бүртгэгдэн, 586 хүн нас барж, хүн амын цэвэр өсөлт 1584 болов.

Хүн амын ердийн хөдөлгөөний сүүлийн 11 жилийн тайлангаас үзэхэд төрөлт өмнөх жилүүдэд дунджаар -4.7 хувиар буурч байснаа сүүлийн 3 жилд дунджаар 29.91%-иар төрөлт өсөж байгаа нь хүүхдийн мөнгө олголт зохих нөлөө үзүүлсэнтэй холбоотой. Төрөх насны эмэгтэйчүүдийн болон 1000 хүн амд ногдох төрөлт аймгийн дүнгээр 2.13 хувиар өслөө. Тухайлбал 20-34 насны хоорондох эмэгтэйчүүдийн төрөлт 27.6 хувиар нэмэгдсэн, сүүлийн 6 жилээр үзэхэд 20-24 насны эмэгтэйчүүдийн 1000 хүнд төрөлт 2004 онд 127, 2005 онд 118, 2006 онд 123, 2007 онд 120, 2008 онд 142, 2009 онд 147 болж гарлаа. 25-29 насны эмэгтэйчүүдийн 1000 хүнд ногдох төрөлт 2004 онд 129, 2005 онд 112, 2006 онд 113, 2007 онд 142, 2008 онд 153, 2009 онд 166, 30-34 насны эмэгтэйчүүдийн 1000 хүнд ногдох төрөлт 2004 онд 73, 2005 онд 59, 2006 онд 75, 2007 онд 41, 2008 онд 95, 2009 онд 126 байгаа нь судалгаагаар гарлаа. Дээрхи судалгаанаас харахад нас баралт 1995-2000 он хүртэл буурах хандлагатай байсан бол 2001 онд өмнөх оноос 11,1 хувиар өсч, 2002 оноос хойш хэвийн хэмжээндээ жилд дунджаар 580 орчим байна. 2009 онд нас барсан хүмүүст 60-69 насны хүмүүсийн эзлэх хувь 13.99%, 70-79 насных 20.30%, 80-89 насных 11,26%, 90-ээс дээш насных 3,75% болж, нийт нас барсан хүмүүсийн 49.65%-г 60-аас дээш насны хүмүүс эзлэж, өмнөх оноос 1,55 хувиар буурлаа.

Нийт хүн амд 0-7 насны хүүхэд 14.16 хувь буюу 12.3 мянга, 0-15 насны хүүхэд, залуучууд 28.70 хувь буюу 25.0 мянга, 0-34 насны хүүхэд, залуучууд 65.65 хувь буюу 57.3 мянга боллоо. Хүн амд (55 наснаас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэйчүүд) өндөр настангууд 10.0 хувь буюу 8.7 мянга байгаагийн 70.90 хувь нь 55-69 хүртэл насных, 21.99 хувь нь 70-79 насных, 6.07 хувь нь 80-89 насных, 1,04 хувь нь 90-ээс дээш насны ахмадууд эзлэв. 2009 оны жилийн эцсийн байдлаар хүн ам зүйн ачаалал 100 хүнд 45.9 тэжээгч хүн ногдлоо. Хүн амын тоо өмнөх оноосоо 1.7 мянгаар буурсан нь аймгийн шилжилт хөдөлгөөнөөр буурлаа.

Аймгийн хэмжээнд 26119 өрх байгаагийн 51.17 хувь буюу 13365 нь аймаг, сумын төвд, 48.83 хувь буюу 12754 нь хөдөөд бүртгэгдлээ. Өрхийн тоо 2008 оны жилийн эцсээс 1.04 хувиар өслөө. Аймгийн дүнгээр нэг өрхийн дундаж ам бүл 3,3 байгаагаас аймгийн төвийн нэг өрхийнх 3.3, сумын төвийн нэг өрхийнх 3.6, хөдөөгийнх 2.8 байгаа нь төв сууринд хүн амын нягтрал их байгаагийн илрэл юм.

2009 оны жилийн эцсийн өрх хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн тайлангаар аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 141, хагас өнчин хүүхэд 1311 гарлаа. 2008 оноос бүтэн өнчин хүүхдийн тоо 1.4%-иар, хагас өнчин хүүхдийн тоо 8.13%-иар тус бүр буурлаа. Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн тайлангаар гэр бүлгүй эх 1186, эцэг 222, өрх толгойлсон эмэгтэйчүүд 2334, эрэгтэйчүүд 1024 гарч, гэр бүлгүй эрэгтэйчүүд өмнөх оныхоос 12.28-иар өсч, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 11.8-иар буурлаа. Аймгийн нийт өрхөд 8-с дээш ам бүлтэй өрх 0.8%, ганц бие өндөр настан өрх 4.3%-ийг эзлэв.

Нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настнууд 24 гарсан нь өмнөх оноос 36.8%-иар буурч, ийм ахмадуудын тоо Жаргалант, Эрдэнэ, Батсүмбэр, Баянцогт зэрэг сумдад харьцангуй (4-2) олон гарлаа.

Тэтгэвэр, тэтгэмж авдаггүй ахмадуудад эрэгтэйчүүд 37.5%, эмэгтэйчүүд 62.5%-ийг эзлэв. Тахир дутуу хүмүүсийн тоо 2694, үүнээс эмэгтэйчүүд 41.20 хувь, тахир дутуу хүмүүсийн 37.49 нь төрөлхийн, 51.93% нь ердийн өвчний, 2.15% нь мэргэжлээс шалтгаалах өвчний, 6.49% нь ахуйн осол, 1,93% нь үйлдвэрийн ослоор тахир дутуу болжээ. Тахир дутуу хүмүүсийг өвчний шалтгаанаар нь үзвэл: 6.60% нь харах эрхтний өөрчлөлттэй, 10.98 нь сонсгол, хэл ярианы согогтой, 15.59% нь хөдөлгөөний согогтой, 20.15% нь оюун ухааны хомсдолтой, 8.35% нь сэтгэцийн эмгэгтэй, 7.01% нь хавсарсан согогтой, 31.29% нь бусад хэлбэрийн өвчтэй хүмүүс эзлэв. Тахир дутуу хүмүүсийн тоо 2008 оныхоос 3.03 хувиар буурч байгаа нь хуулийн өөрчлөлт болон группээс гарсан хүний тоогоор буурлаа.



### III. СУДАЛГАА

1995-2009 оны хоорондох хүн амын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

1995-2009 оны хоорондох хүн амын тоог хронологийн дунджын аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{y_1 + y_2 + \dots + y_{n-1} + y_n}{n-1} = \frac{1432211}{15} = 95480$$

1995-2009 оны хооронд хүн амын тоо нь дунджаар 95480 мянга байна.

1994-2009 оны хүн амын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

#### Суурин хүн амын динамик эгнээний хэлхээ үндсэн

Суурин хүн амын динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолвол:

Онууд	Суурин хүний тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд%	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
1994	105741				
1995	103721	-2020	98.09	-1.91	1057
1996	104238	517	100.50	0.50	1037
1997	104592	354	100.34	0.34	1042
1998	103537	-1055	98.99	-1.01	1046
1999	101112	-2425	97.66	-2.34	1035
2000	99268	-1844	98.18	-1.82	1011
2001	95706	-3562	96.41	-3.59	993
2002	96716	1010	101.06	1.06	957
2003	92816	-3900	95.97	-4.03	967
2004	88627	-4189	95.49	-4.51	928
2005	88491	-136	99.85	-0.15	886
2006	88460	-31	99.96	-0.04	885
2007	88828	368	100.42	0.42	885
2008	88889	61	100.07	0.07	888
2009	87210	-1679	98.11	-1.89	889

Дээрх хүснэгтээс харахад 2009 онд хүн амын тоо 1994 оныхоос 18531 хүнээр буюу 21.24 хувиар буурахад бууралтийн 1.0 хувьд 889 хүн ногдлоо.

1994 оноос хойших хүн амын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

$K = \sqrt[15]{1 * 0.9809 * 1.0050 * \dots * 1.0042 * 1.0007 * 0.9811} = \bar{K} = 1 = \sqrt[15]{0.82490215} = 0.98804$  буюу 98.804% гарсан нь 1994 оноос хойш хүний тоо жилд дунджаар -1.196 хувиар буурлаа.

Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

**Суурин хүн амын динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:**

Онууд	Суурин хүний тоо	Суурь абсолют цэвэр өсөлт (тоо)	Суурь өсөлтийн хурд 1995=100%	Суурь цэвэр өсөлтийн хурд %
1995	103721		100.0	
1996	104238	517	100.50	0.50
1997	104592	871	100.84	0.84
1998	103537	-184	99.82	-0.18
1999	101112	-2609	97.48	-2.52
2000	99268	-4453	95.71	-4.29
2001	95706	-8015	92.27	-7.73
2002	96716	-7005	93.25	-6.75
2003	92816	-10905	89.49	-10.51
2004	88627	-15094	85.45	-14.55
2005	88491	-15230	85.32	-14.68
2006	88460	-15261	85.29	-14.71
2007	88828	-14893	85.64	-14.36
2008	88889	-14832	85.70	-14.30
2009	87210	-16511	84.08	-15.92

**Динамик хандлагын шинжилгээ /прогнозчлол/.**

Эдийн засгийн аливаа үзэгдэлийг динамикаар судлах үед түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол буюу динамик чиг хандлагыг тодорхойлох шаардлага тавигддаг. Төв аймгийн хүний тооны өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнчлэн дараагийн 5 жилийн прогноз боловсруулахын тулд динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлж тооцоо хийх аргыг ашиглаж болох юм. Ингэхдээ 1994-2009 оны хооронд динамик хандлагын шинжилгээг хийлээ. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга гэдэг нь судлагдаж байгаа түвшингүүдийг хугацаанаас хамаарсан функц гэж үзээд динамик эгнээний өгөгдсөн түвшингүүдийг бага хэлбэлзэл бүхий түвшингүүдээр солих арга юм.

Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх аргыг ашиглан 1994-2009 онуудад хүн амын төрөлт, шилжилт зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүй байсан бол хүн амын тоо ямар түвшинд хүрэх байсан бэ, мөн цаашид дээрхи хүчин зүйлүүд нөлөөлөхгүйгээр байвал 2010-2012 онуудад хэдэд хүрэхээр байна нь вэ гэдгийг гаргаж үзлээ. Бидний авч үзэж байгаа динамик эгнээг графикаар дүрсэлж үзэхэд дараахь хэлбэртэй байна.



1994 оноос хойшхи 15 жилийн хүн амын тооны бодит утга дээр тулгуурлан шулуун шугамын аргыг ашиглаж тэгшитгэсэн утгыг гаргая.

Тэгшитгэл нь  $y_{(t)} = a + bt$  томъёогоор илэрхийлнэ. Үүнд:

t- хугацаа

a, b- тэгшитгэлийн параметрууд

$$\begin{cases} a + b \sum t = \sum y \\ a \sum t + b \sum t^2 = \sum yt \end{cases}$$

Тэгшитгэлийн параметруудийг дараах систем тэгшитгэлээр бодох бөгөөд

Систем тэгшитгэлийн бодолтыг хялбарчилахын тулд  $\sum t = 0$  байхаар хугацаанд t

гэсэн код өгвөл системт тэгшитгэл

$$\begin{cases} na = \sum y \\ b \sum t^2 = \sum yt \end{cases} \text{ болно.}$$

Системт тэгшитгэлийг бодож гаргахын тулд дараахь тооцооллуудыг хийе.

$Y_t$ - хүн амын тоо, t- хугацаа

$$\text{Эндээс } a = 1432211/15 = 95480.73$$

$b = -408834/280 = -1460.12$  болж,  $y_t = 95480.73 - 1460.12t$  гэсэн динамик хандлагын тэгшитгэл гарлаа.

Уг тэгшитгэлийг ашиглан 1994-2009 онуудад ямар нэгэн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл байгаагүй бол хүн амын тоо хэдэд хүрэх байж вэ, цаашид 2009-2012 онуудад хэдэд хүрэх вэ гэсэн  $y_t$  утгыг гарган авахад доорхи байдалтай байна.

## Хүснэгт 3.

	Y	T	t <sup>2</sup>	y*t	y <sub>t</sub> =a+bt
<b>1995</b>	103721	-7	49	-726047	105701.57
<b>1996</b>	104238	-6	36	-625428	104241.45
<b>1997</b>	104592	-5	25	-522960	102781.33
<b>1998</b>	103537	-4	16	-414148	101321.21
<b>1999</b>	101112	-3	9	-303336	99861.09
<b>2000</b>	99268	-2	4	-198536	98400.97
<b>2001</b>	95706	-1	1	-95706	96940.85
<b>2002</b>	96716	0	0	0	95480.73
<b>2003</b>	92816	1	1	92816	94020.61
<b>2004</b>	88627	2	4	177254	92560.49
<b>2005</b>	88491	3	9	265473	91100.37
<b>2006</b>	88460	4	16	353840	89640.25
<b>2007</b>	88828	5	25	444140	88180.13
<b>2008</b>	88889	6	36	533334	86720.01
<b>2009</b>	87210	7	49	610470	85259.89
<b>Дүн</b>	<b>1432211</b>	<b>0</b>	<b>280</b>	<b>-408834</b>	
2010		10		-	80879.53
2011		11		-	79419.41
2012		12			77959.29

## Хүснэгт4

	Y	y <sub>t</sub> =a+bt
1995	103721	105701.57
1996	104238	104241.45
1997	104592	102781.33
1998	103537	101321.21
1999	101112	99861.09
2000	99268	98400.97
2001	95706	96940.85
2002	96716	95480.73
2003	92816	94020.61
2004	88627	92560.49
2005	88491	91100.37
2006	88460	89640.25
2007	88828	88180.13
2008	88889	86720.01
2009	87210	85259.89
<b>2010</b>	-	<b>80879.53</b>
<b>2011</b>	-	<b>79419.41</b>
<b>2012</b>	-	<b>77959.29</b>


y- бодит утга буюу гүйцэтгэлээр гарсан хүн амын тоо

y<sub>t</sub>- тэгшитгэлээр гарсан хүн амын тоо

### Цикл хэлбэлзэлийн шинжилгээ

Динамик хандлагын шинжилгээг хийхдээ хэдийгээр цикл болон гэнэтийн хэлбэлзлийг динамик эгнээнийн бүрэлдэхүүнээс арилгаж математик тэгшитгэлд шилжүүлдэг боловч тухайн үзэгдэлийн цикл хэлбэлзэлийг судлах нь үзэгдлийн өнгөрсөн үеүүдийн хөгжил өөрчлөлтийг илүү тодорхой судалж дүгнэлт гаргахад үр нөлөөтэй байдаг. Цикл хэлбэлзэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцвол

Онууд	Бодит утга	Тэгшитгэсэн утга	Хандлагын хувийн жин	Цикл үлдэгдлийн харьцангуй хэмжигдэхүүн
1995	103721	105702	101.91%	1.91%
1996	104238	104241	100.00%	0.00%
1997	104592	102781	98.27%	-1.73%
1998	103537	101321	97.86%	-2.14%
1999	101112	99861	98.76%	-1.24%
2000	99268	98401	99.13%	-0.87%
2001	95706	96941	101.29%	1.29%
2002	96716	95481	98.72%	-1.28%
2003	92816	94021	101.30%	1.30%
2004	88627	92560	104.44%	4.44%
2005	88491	91100	102.95%	2.95%
2006	88460	89640	101.33%	1.33%
2007	88828	88180	99.27%	-0.73%
2008	88889	86720	97.56%	-2.44%
2009	87210	85260	97.76%	-2.24%



Сумдын суурин хүн ам 1995 оныг 2009 онтой харьцуулсан  
үзүүлэлт

Д/д			Харьцуулсан хувь 2009/1995	Жилийн дундаж өсөлтийн хувь 2009/1995	
	1995	2009			
1	Алтанбулаг	3414	3059	89.60	-0.78
2	Аргалант	2358	1764	74.81	-2.05
3	Архуст	2045	1336	65.33	-3.00
4	Батсүмбэр	6376	6601	103.53	0.25
5	Баян	2585	1984	76.75	-1.87
6	Баяндэлгэр	2331	1243	53.32	-4.39
7	Баянжаргалан	1762	1596	90.58	-0.70
8	Баянөнжүүл	3016	2214	73.41	-2.18
9	Баянхангай	1661	1468	88.38	-0.88
10	Баянцагаан	2643	2016	76.28	-1.92
11	Баянцогт	3837	2013	52.46	-4.50
12	Баянчандмань	3810	3364	88.29	-0.89
13	Борнуур	4431	4611	104.06	0.28
14	Бүрэн	3521	3032	86.11	-1.06
15	Дэлгэрхаан	2372	1883	79.38	-1.64
16	Жаргалант	5787	5971	103.18	0.22
17	Заамар	4999	5472	109.46	0.65
18	Лүн	3047	2518	82.64	-1.35
19	Мөнгөнморьт	2294	1990	86.75	-1.01
20	Өндөрширээт	2532	1886	74.49	-2.08
21	Сүмбэр	2140	1668	77.94	-1.76
22	Сэргэлэн	2536	1957	77.17	-1.83
23	Угтаал	4140	2330	56.28	-4.02
24	Цээл	3721	2388	64.18	-3.12
25	Эрдэнэ	3377	3525	104.38	0.31
26	Эрдэнэсант	5701	4550	79.81	-1.60
27	Зуунмод	17285	14771	85.46	-1.12
	<b>Дүн</b>	<b>103721</b>	<b>87210</b>	<b>84.08</b>	<b>-1.23</b>

Мөн хүн амын тоо 2010 онд хэдэд хүрч болохыг прогноз хийж үзлээ.

**Хүснэгт 7.**

	<b>Бодит утга- у</b>	<b>тэгшитгэ лийн утга -у<sub>t</sub></b>	<b>у-у<sub>t</sub></b>	<b>(у-у<sub>t</sub>)<sup>2</sup></b>
1995	103.721	105.701	-1.980	3.920
1996	104.238	104.241	-0.003	0.000
1997	104.592	102.781	1.811	3.280
1998	103.537	101.321	2.216	4.911
1999	101.112	99.861	1.251	1.565
2000	99.268	98.400	0.868	0.753
2001	95.706	96.940	-1.234	1.523
2002	96.716	95.480	1.236	1.528
2003	92.816	94.020	-1.204	1.450
2004	88.627	92.560	-3.933	15.468
2005	88.491	91.100	-2.609	6.807
2006	88.460	89.640	-1.180	1.392
2007	88.828	88.180	0.648	0.420
2008	88.889	86.720	2.169	4.705
2009	87.210	85.259	1.951	3.806
<b>Дүн</b>				<b>51.528</b>

Үүний тулд доорхи томъёог ашиглана.  $y \pm t_{\alpha} * \delta_y$   $\delta_y$  -хандлагын (трэндийн) квадрат

дундаж хазайлт  $\delta_y = \sqrt{\frac{\sum (y - y_t)^2}{n - 1}} = \sqrt{\frac{51.528}{15 - 1}} = \sqrt{3,6805} = 1,918481$   $t_{\alpha}$ -к чөлөөний зэрэг

бүхий Стьютендийн тархалт  $k = n - 1 = 15 - 1 = 14$ ,  $t(0.05, 14) = 2.144788596$ ;

$t_{\alpha} * \delta_y = 2.144788596 * 1.91848 = 4,114$ ; 2010 оны түвшин  $80879.53 + 4.114 = 84993.53$ ;

$80879.53 - 4,114 = 76765.53$  95.0 хувийн магадлалтайгаар 2010 оны түвшин

$76765 < y_{\text{прог}} < 84993$  байна. 2010 онд хүн амын тоо 76765-ээс 84993.53 хооронд байх ба

энэ нь 95.0 хувийн магадлалтай гэсэн үг юм.

## ДҮГНЭЛТ, САНАЛ.

Хүн ам, нийгмийн статистик мэдээ, тайлангуудын гаргалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд: Суурин хүн амын (ХА-3 ) тайлан, Хүн амын шилжилт хөдөлгөөний (ХА-2) тайлан, Хүн ам, өрхийн нийгмийн зарим үзүүлэлтийн (НС-1) тайлангуудын маягтын үзүүлэлт, зааварыг ҮСХ-ноос баталж ирүүлсэн 2003 оны жилийн эцсээс эхлэн үндсэн нэгжүүдэд мөрдүүлэн ажиллаж жил бүр судалгааг хийж хэвшлээ.

Суурин хүн амын тоо 1995 оноос хойш жил бүр дунджаар -1,196 хувиар буурч байгаа нь:

- Улс орон зах зээлд шилжсэнээс хойш, ажлын байр багассан, амьжиргааны өртөг нэмэгдсэн зэрэг нөлөөллөөс хүн ам төв, суурин газар руу шилжих урсгал нэмэгдэж 2004-2005 онд 7-3 мянгад хүрч, сүүлийн жилд 0.8-аар мянгаар буурах хандлагатай боллоо.
- Хүн амын цэвэр өсөлт 2000 онд 1000 хүнд ногдох төрөлт 19.7, нас баралт 6, цэвэр өсөлт 13-аар буурч байсан бол, 2009 онд төрөлт 25, нас баралт 7, цэвэр өсөлт 18 болж өсөж байгаа юм шиг боловч хүн ам нэмэгдэхэд нөлөөлөхгүй байна.
- Хүн ам ихтэй Зуунмодын 6 баг 1162-270, Батсүмбэрийн 4 баг 723-317, Жаргалантын 4 баг 651-210, Эрдэнэсантын 5 баг 416-169 өрхтэй байхад Баян сумын хөдөөний 1, 2 баг 112-115, Баянцагаан сумын 5 баг 145-111, Бүрэн сумын баг 203-126, Сэргэлэн сумын 5 баг 184-110, Цээл сумын 4 баг 188-93 өрхтэй байна.

Харин аймгийн хэмжээнд төрөлт сүүлийн 3 жилд дунджаар 24.90 хувиар өссөн эерэг хандлага гарлаа.

### Цаашид:

- Сумдад ажлын байрыг бий болгоход төрөл бүрийн хөрөнгийн эх үүсвэрийг чиглүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд зах зээлийн жишигт нийцүүлсэн техник, технологи, менежментийн арга барилыг нэвтрүүлэх эзэмшүүлэх зэргээр хамгийн оновчтой хэлбэрээр үр өгөөжтэй ашиглан хүн амьдрах таатай орчинг бүрдүүлэн хүн амын шилжих хөдөлгөөний урсгалыг сааруулах явдал тулгамдсан зорилт боллоо.
- Багийн хүн ам, малын тоо, газар нутгийн хэмжээ, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, дэд бүтцийн хөгжлийн төвшин зэрэг үзүүлэлтийг харгалзан төв, хөдөөгийн багийн аймгийн дундажийг ялгавартайгаар тогтоож мөрдөн хэрэгжүүлэхийг зөвлөө.

Статистикийн хэлтсийн дарга

Ж.Отгончулуун

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд.
2. Сумдын өрхийн тоо, тэдгээрийн байршилын үзүүлэлтүүд
3. Сумдын хүн амын тоо, тэдгээрийн байршилын үзүүлэлтүүд
4. Сумдын суурин хүний тоо хүйсээр
5. Сумдын нийт хүн амд хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин
6. Сумдын нийт хүн амын насны ерөнхий бүтэц, хүн ам зүйн ачаалал
7. Сумдын нийт хүн амд өндөр настангуудын эзлэх хувь, өндөр настнуудын насны бүтцийн үзүүлэлтүүд
8. нийт өндөр настанд эмэгтэй өндөр настануудын эзлэх хувь, насны бүтцийн үзүүлэлтүүд
9. Хүн ам, өрхийн тоо багаар
10. Бүтэн өнчин хүүхдүүд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоо
11. Бүтэн өнчин хүүхдүүд насны бүлэг, хүйсээр
12. Хагас өнчин хүүхдийн тоог сумдаар
13. Хагас өнчин эрэгтэй хүүхдийн тоог сумдаар
14. Хагас өнчин эмэгтэй хүүхдийн тоог сумдаар
15. Гэр бүлгүй (16 хүртэл насны) хүүхэдтэй эх, эцгийн тоог сумдаар
16. Өрх толгойлсон гэр бүлгүй хүн ам бүлийн тоогоор, олон ам бүлтэй өрхүүдийн тоог сумдаар
17. Өрх толгойлсон гэр бүлгүй хүн, ам бүлийн тоог сумдаар
18. Өндөр настан ганц бие өрх, тэтгэвэр, тэтгэмж, тогтоогдоогүй өндөр настай хүний тоог сум, байршлаар
19. Тахир дутуу хүмүүсийн тоо сумдаар
20. Тахир дутуу хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
21. Тахир дутуу хүмүүсээс хөдөлмөрийн насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
22. Тахир дутуу хүмүүсээс хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
23. Тахир дутуу хүмүүсээс харах эрхтний өөрчлөлттэй хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
24. Харах эрхтний өөрчлөлттэй хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум хүйс, шалтгаанаар
25. Тахир дутуу хүмүүсээс сонсгол, хэл ярианы согогтой хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
26. Сонсгол, хэл ярианы согогтой хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум хүйс, шалтгаанаар
27. Тахир дутуу хүмүүсээс хөдөлгөөний согогтой хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
28. Хөдөлгөөний согогтой хүмүүсээс 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
29. Тахир дутуу хүмүүсээс оюун ухааны хомсдолтой хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
30. Оюун ухааны хомсдолтой 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
31. Тахир дутуу хүмүүсээс сэтгэцийн эмгэгтэй хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
32. Сэтгэцийн эмгэгтэй 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
33. Тахир дутуу хүмүүсээс хавсарсан согогтой хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
34. Хавсарсан согогтой 0-15 насны хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
35. Тахир дутуу хүмүүсээс бусад хэлбэрийн тахир дутуу хүний тоо, сум, хүйс, шалтгаанаар
36. Нийт хүн амд 15-49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин
37. Сумдын хүн амын ердийн хөдөлгөөний талаархи мэдээлэл
38. Хүн амын нийгмийн холбоотой үр дүнгийн үзүүлэлтүүд
39. Хүн амын ердийн хөдөлгөөний тайланг ашиглан хийсэн зэрэгцүүлсэн судалгаа (төрөлт)
40. Хүн амын ердийн хөдөлгөөний тайланг ашиглан хийсэн зэрэгцүүлсэн судалгаа (нас баралт)
41. 2009 оны хүн амын шилжих хөдөлгөөний тайлангаас хийсэн товч нэгтгэл.



Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд.	Хэмжих нэгж	2009 оны				
		Аймгийн дундаж	Хамгийн			
			их	бага		
Хүн амын тоогоор	хүн	<b>3230</b>	<b>Зуунмод</b>	<b>14771</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>1243</b>
			Батсүмбэр	6601	Архуст	1336
			Жаргалант	5971	Баянхангай	1468
			Заамар	5472	Баянжаргалан	1596
			Борнуур	4611	Сүмбэр	1668
Хүн амын нягтрал	хүн	<b>1.2</b>	<b>Зуунмод</b>	<b>770.13</b>	<b>Мөнгөнморьт</b>	<b>0.30</b>
			Баянчандмань	5.49	Баянцагаан	0.31
			Сүмбэр	4.78	Эрдэнэ	0.44
			Борнуур	4.02	Баяннөжүүл	0.46
			Жаргалант	3.20	Сэргэлэн	0.51
Өрхийн тоогоор	өрх	<b>967</b>	<b>Зуунмод</b>	<b>4422</b>	<b>Архуст</b>	<b>407</b>
			Батсүмбэр	1868	Баянхангай	448
			Жаргалант	1760	Баянжаргалан	461
			Заамар	1533	Сүмбэр	498
			Борнуур	1337	Баяндэлгэр	502
Өрхийн дундаж ам бүл	хүн	<b>3.3</b>	Бүрэн	<b>3.7</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>2.5</b>
			Эрдэнэсант	3.6	Мөнгөнморьт	2.8
			Баяннөжүүл	3.6	Сүмбэр	2.8
			Заамар	3.6	Эрдэнэ	3.0
			Цээл	3.6	Баянчандмань	3.0
Хүйсийн харьцаа 100 эмэгтэйд ноогдох эрэгтэй	хүн	<b>101.2</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>123.6</b>	<b>Зуунмод</b>	<b>92.3</b>
			Сэргэлэн	112.0	Баян	97.6
			Баянцогт	109.7	Угтаал	98.3
			Өндөрширээт	108.6	Баянхангай	99.5
			Архуст	107.1	Бүрэн	99.5
Хүн ам зүйн ачаалал	хувь	<b>45.9</b>	<b>Дэлгэрхаан</b>	<b>54.6</b>	<b>Аргалант</b>	<b>36.9</b>
			Бүрэн	53.3	Зуунмод	40.9
			Баян	52.5	Сэргэлэн	42.1
			Батсүмбэр	51.0	Цээл	42.9
			Баянхангай	49.3	Мөнгөнморьт	43.9
Өндөр настны тоогоор	хүн	<b>321</b>	<b>Зуунмод</b>	<b>1595</b>	<b>Баянхангай</b>	<b>124</b>
			Батсүмбэр	783	Архуст	129
			Жаргалант	536	Баянжаргалан	138
			Борнуур	449	Баяндэлгэр	141
			Эрдэнэсант	419	Сүмбэр	142
Өндөр настан эмэгтэйчүүдийн тоогоор	хүн	<b>170</b>	<b>Зуунмод</b>	<b>888</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>62</b>
			Батсүмбэр	407	Архуст	62
			Жаргалант	285	Баянхангай	64
			Борнуур	248	Баянжаргалан	68
			Эрдэнэсант	222	Аргалант	87
1000 хүнд ногдох төрөлтийн тоогоор	хүн	<b>24.7</b>	<b>Бүрэн</b>	<b>29.2</b>	<b>Аргалант</b>	<b>16.1</b>
			Баянжаргалан	27.5	Баянцогт	18.8
			Зуунмод	26.9	Алтанбулаг	19.7
			Заамар	26.9	Баяннөжүүл	20.3
			Архуст	25.4	Баянцагаан	21.4

Үзүүлэлтүүд.	Хэмжих нэгж	2009 оны				
		Аймгийн дундаж	Хамгийн		бага	
			их			
1000 хүнд ногдох нас баралтын тоогоор	хүн	<b>6.7</b>	<b>Архуст</b>	<b>10.5</b>	<b>Баянхангай</b>	<b>2.7</b>
			Батсүмбэр	9.8	Лүн	4.0
			Сүмбэр	8.9	Эрдэнэсант	4.2
			Өндөрширээт	8.8	Баян-Өнжүүл	4.4
			Зуунмод	8.3	Баянжаргалан	4.4
1000 хүнд ногдох цэвэр өсөлт тоогоор	хүн	<b>18.0</b>	<b>Бүрэн</b>	<b>24.0</b>	<b>Аргалант</b>	<b>8.6</b>
			Баянжаргалан	23.1	Баянцогт	13.3
			Заамар	21.3	Өндөрширээт	14.5
			Батсүмбэр	20.9	Мөнгөнморьт	14.8
			Баянчандмань	20.1	Сүмбэр	14.8
10000 хүнд ногдох эмнэлгийн ор	ор	<b>66.3</b>	<b>Зуунмод</b>	<b>239.7</b>	<b>Батсүмбэр</b>	<b>21.5</b>
			Баяндэлгэр	49.8	Жаргалант	21.9
			Архуст	44.9	Заамар	22.9
			Баянжаргалан	43.8	Эрдэнэ	25.5
			Лүн	40	Баянчандмань	27.9
10000 хүнд ногдох хүний их эмч	хүн	<b>15.6</b>	<b>Зуунмод</b>	<b>54.6</b>	<b>Эрдэнэ</b>	<b>2.8</b>
			Жаргалант	11.7	Бүрэн	3.3
			Эрдэнэсант	10.9	Баян-Өнжүүл	4.4
			Заамар	10.6	Баян	4.9
			Сэргэлэн	10.4	Баянцагаан	4.9
10000 хүнд ногдох эмнэлгийн дунд мэргэжилтэн	хүн	<b>53.6</b>	<b>Зуунмод</b>	<b>115.9</b>	<b>Батсүмбэр</b>	<b>23.0</b>
			Баяндэлгэр	82.9	Жаргалант	25.1
			Баянхангай	75.6	Заамар	24.7
			Баян	69.0	Алтанбулаг	29.5
			Архуст	67.3	Баянчандмань	30.7
10000 хүнд ногдох Е.Б.Сургуульд суралцагсад	хүн	<b>390</b>	<b>Мөнгөнморьт</b>	<b>2301</b>	<b>Угтаал</b>	<b>199.7</b>
			Заамар	2157	Зуунмод	<b>649.2</b>
			Баянчандмань	2053	Баян-Өнжүүл	815.3
			Цээл	2041.8	Баянцагаан	875.9
			Борнуур	1985	Сүмбэр	1060
10000 хүнд ногдох үзвэр үзэгчид	хүн	<b>30901.1</b>	<b>Баянцогт</b>	<b>63733</b>	<b>Баянцагаан</b>	<b>2822</b>
			Цээл	58455	Алтанбулаг	7996
			Аргалант	55268	Заамар	8909
			Баянжаргалан	53188	Баян-Өнжүүл	14103
			Эрдэнэсант	47023	Бүрэн	15210

Сумдын өрхийн тоо, тэдгээрийн байршлыг үзүүлбэл:

	Нийт өрхийн		Ү Ү Н Э Э С				Өрхийн дундаж ам бүл	Аймгийн дүнд эзлэх хувийн жин
	тоо		хот суурин, сумын төв		Хөдөөд			
	Эцэст		тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь		
	2008 оны	2009 оны						
1.Алтанбулаг	861	894	266	29.75	628	70.25	3.42	3.42
2.Аргалант	454	534	265	49.63	269	50.37	3.30	2.04
3.Архуст	394	407	194	47.67	213	52.33	3.28	1.56
4.Батсүмбэр	1775	1868	723	38.70	1145	61.30	3.53	7.15
5.Баян	591	616	399	64.77	217	35.23	3.22	2.36
6.Баяндэлгэр	467	502	161	32.07	341	67.93	2.48	1.92
7.Баянжаргалан	455	461	169	36.66	292	63.34	3.46	1.76
8.Баян-Өнжүүл	618	618	53	8.58	565	91.42	3.58	2.37
9.Баянхангай	416	448	199	44.42	249	55.58	3.28	1.72
10.Баянцагаан	629	627	120	19.14	507	80.86	3.22	2.40
11.Баянцогт	605	616	262	42.53	354	57.47	3.27	2.36
12.Баянчандмань	1093	1117	98	8.77	1019	91.23	3.01	4.28
13.Борнуур	1303	1337	331	24.76	1006	75.24	3.45	5.12
14.Бүрэн	819	828	156	18.84	672	81.16	3.66	3.17
15.Дэлгэрхаан	531	538	205	38.10	333	61.90	3.50	2.06
16.Жаргалант	1676	1760	1253	71.19	507	28.81	3.39	6.74
17.Заамар	1615	1533	1172	76.45	361	23.55	3.57	5.87
18.Лүн	723	754	43	5.70	711	94.30	3.34	2.89
19.Мөнгөнморьт	662	700	668	95.43	32	4.57	2.84	2.68
20.Өндөрширээт	596	580	116	20.00	464	80.00	3.25	2.22
21.Сүмбэр	469	498	382	76.71	116	23.29	3.35	1.91
22.Сэргэлэн	559	688	56	8.14	632	91.86	2.84	2.63
23.Угтаал	648	678	410	60.47	268	39.53	3.44	2.60
24.Цээл	674	671	372	55.44	299	44.56	3.56	2.57
25.Эрдэнэ	1116	1170	452	38.63	718	61.37	3.01	4.48
26.Эрдэнэсант	1165	1254	418	33.33	836	66.67	3.63	4.80
27.Зуунмод	4180	4422	4422	6.00		0.00	3.34	16.93
<b>Аймгийн дүн</b>	<b>25094</b>	<b>26119</b>	<b>13365</b>	<b>51.17</b>	<b>12754</b>	<b>48.83</b>	<b>3.34</b>	<b>100.0</b>
<b>Б ү с-</b> Төвийн бүс	6847	7249	4917	67.83	2332	32.17	3.31	27.75
<b>ү ү д-</b> Хойт бүс	7375	7730	3314	42.87	4416	57.13	3.36	29.60
<b>ий н</b> Баруун бүс	7187	7284	3091	42.44	4193	57.56	3.50	27.89
<b>д ү н</b> Зүүн бүс	3685	3856	2043	52.98	1813	47.02	3.03	14.76
2008 он		25094	14037	55.94	11057	44.06	3.54	
2007 он		24746	14053	56.79	10693	43.21	3.59	
2006 он		23973	13741	57.32	10232	42.68	3.80	
2005 он		23309	13345	57.25	9964	42.75	3.80	
2004 он		22498	12483	55.48	10015	44.52	3.90	
2003 он		23257	12824	55.14	10433	44.86	4.00	
2002 он		23710	12626	53.25	11084	46.75	4.10	
2001 он		23466	12400	52.84	11066	47.16	4.10	
2000 он		23678	11531	48.70	12147	51.30	4.10	
1999 он		24619	12390	50.33	12229	49.67	4.10	

Сумдын хүн амын тоо, тэдгээрийн байршлыг үзүүлбэл:

	Суурин хүн амын			Ү Ү Н Э Э С				Аймгийн дүнд эзлэх хувийн жин
	тоо			хот, суурин, сумын төв		хөдөөд		
	2007 оны эцэст	2008 оны эцэст	2009 оны эцэст	тоо	хувийн жин	тоо	хувийн жин	
1.Алтанбулаг	3079	3044	3059	895	29.26	2164	70.74	3.51
2.Аргалант	1955	1964	1764	924	52.38	840	47.62	2.02
3.Архуст	1371	1339	1336	651	48.73	685	51.27	1.53
4.Батсүмбэр	6525	6420	6601	2591	39.25	4010	60.75	7.57
5.Баян	2093	2072	1984	1290	65.02	694	34.98	2.27
6.Баяндэлгэр	1165	1169	1243	382	30.73	861	69.27	1.43
7.Баянжаргалан	1623	1604	1596	569	35.65	1027	64.35	1.83
8.Баянөнжүүл	2560	2324	2214	178	8.04	2036	91.96	2.54
9.Баянхангай	1401	1443	1468	614	41.83	854	58.17	1.68
10.Баянцагаан	2173	2094	2016	405	20.09	1611	79.91	2.31
11.Баянцогт	2020	2032	2013	927	46.05	1086	53.95	2.31
12.Баянчандмань	3322	3797	3364	304	9.04	3060	90.96	3.86
13.Борнуур	4693	4677	4611	1149	24.92	3462	75.08	5.29
14.Бүрэн	3209	3056	3032	574	18.93	2458	81.07	3.48
15.Дэлгэрхаан	2016	1920	1883	726	38.56	1157	61.44	2.16
16.Жаргалант	5781	5981	5971	4299	72.00	1672	28.00	6.85
17.Заамар	5816	5887	5472	4154	75.91	1318	24.09	6.27
18.Лүн	2515	2485	2518	115	4.57	2403	95.43	2.89
19.Мөнгөнморьт	1902	1938	1990	1924	96.68	66	3.32	2.28
20.Өндөрширээт	2006	1982	1886	360	19.09	1526	80.91	2.16
21.Сүмбэр	1646	1709	1668	1340	80.34	328	19.66	1.91
22.Сэргэлэн	1884	1893	1957	109	5.57	1848	94.43	2.24
23.Угтаал	2274	2276	2330	1402	60.17	928	39.83	2.67
24.Цээл	2352	2402	2388	1350	56.53	1038	43.47	2.74
25.Эрдэнэ	3607	3531	3525	1369	38.84	2156	61.16	4.04
26.Эрдэнэсант	5010	4586	4550	1481	32.55	3069	67.45	5.22
27.Зуунмод	14830	15264	14771	14771	100.00		0.00	16.94
<b>Аймгийн дүн</b>	<b>88828</b>	<b>88889</b>	<b>87210</b>	<b>44853</b>	<b>51.43</b>	<b>42357</b>	<b>48.57</b>	<b>100.0</b>
<b>Б ү с-</b> Төвийн бүс	24526	24619	24017	16358	68.11	7659	31.89	27.54
<b>ү ү д-</b> Хойт бүс	25942	26580	25992	11534	44.38	14458	55.62	29.80
<b>ий н</b> Баруун бүс	26599	26037	25527	10776	42.21	14751	57.79	29.27
<b>д ү н</b> Зүүн бүс	11761	11653	11674	6185	52.98	5489	47.02	13.39
2008 он		88889	50417	56.72	38472	43.28		
2007 он		88828	50712	57.09	38116	42.91		
2006 он		88460	51337	58.03	37123	41.97		
2005 он		88491	51203	57.86	37288	42.14		
2004 он		88627	50563	57.05	38064	42.95		
2003 он		92816	53284	57.41	39532	42.59		
2002 он		96176	53281	55.40	42895	44.60		
2001 он		95706	51966	54.30	43740	45.70		
2000 он		98362	51017	51.87	47345	48.13		
1999 он		101112	52248	51.67	48864	48.33		

Сумдын суурин хүний тоо хүйсээр:

	Нийт хүний тоо	Ү ү н э э с				Хүйсийн харьцаа (100 эмэгтэйд)
		Эрэгтэй		Эмэгтэй		
		тоо	хувийн жин	тоо	хувийн жин	
1.Алтанбулаг	3059	1584	51.78	1475	48.22	107.39
2.Аргалант	1764	899	50.96	865	49.04	103.93
3.Архуст	1336	691	51.72	645	48.28	107.13
4.Батсүмбэр	6601	3325	50.37	3276	49.63	101.50
5.Баян	1984	980	49.40	1004	50.60	97.61
6.Баяндэлгэр	1243	687	55.27	556	44.73	123.56
7.Баянжаргалан	1596	797	49.94	799	50.06	99.75
8.Баян-Өнжүүл	2214	1140	51.49	1074	48.51	106.15
9.Баянхангай	1468	732	49.86	736	50.14	99.46
10.Баянцагаан	2016	1024	50.79	992	49.21	103.23
11.Баянцогт	2013	1053	52.31	960	47.69	109.69
12.Баянчандмань	3364	1691	50.27	1673	49.73	101.08
13.Борнуур	4611	2311	50.12	2300	49.88	100.48
14.Бүрэн	3032	1512	49.87	1520	50.13	99.47
15.Дэлгэрхаан	1883	962	51.09	921	48.91	104.45
16.Жаргалант	5971	3020	50.58	2951	49.42	102.34
17.Заамар	5472	2742	50.11	2730	49.89	100.44
18.Лүн	2518	1283	50.95	1235	49.05	103.89
19.Мөнгөнморьт	1990	1054	52.96	936	47.04	112.61
20.Өндөрширээт	1886	982	52.07	904	47.93	108.63
21.Сүмбэр	1668	839	50.30	829	49.70	101.21
22.Сэргэлэн	1957	1034	52.84	923	47.16	112.03
23.Угтаал	2330	1155	49.57	1175	50.43	98.30
24.Цээл	2388	1214	50.84	1174	49.16	103.41
25.Эрдэнэ	3525	1770	50.21	1755	49.79	100.85
26.Эрдэнэсант	4550	2269	49.87	2281	50.13	99.47
27.Зуунмод	14771	7112	48.15	7659	51.85	92.86
<b>Аймгийн дүн</b>	<b>87210</b>	<b>43862</b>	<b>50.29</b>	<b>43348</b>	49.71	101.19
<b>Б ү с-</b> Төвийн бүс	24017	11894	49.52	12123	50.48	98.11
<b>ү ү д-</b> Хойт бүс	25992	13138	50.55	12854	49.45	102.21
<b>и й н</b> Баруун бүс	25527	12851	50.34	12676	49.66	101.38
<b>д ү н</b> Зүүн бүс	11674	5979	51.22	5695	48.78	104.99
2008 оны эцэст	88889	44766	50.36	44123	49.64	101.46
2007 оны эцэст	88828	44460	50.05	44368	49.95	100.21
2006 оны эцэст	88460	43961	49.70	44499	50.30	98.80
2005 оны эцэст	88491	43986	49.71	44505	50.29	98.80
2004 оны эцэст	88627	44210	49.88	44417	50.12	99.50
2003 оны эцэст	92816	46213	49.79	46603	50.21	99.20
2002 оны эцэст	96176	48238	50.16	47938	49.84	100.63
2001 оны эцэст	95706	48101	50.26	47605	49.74	101.04
2000 оны эцэст	98362	50139	50.97	48223	49.03	103.97
1999 оны эцэст	101112	50629	50.07	50483	49.93	100.29

Сумдын нийт хүн амд хүүхэд, залуучуудын  
эзлэх хувийн жин .

	Нийт хүн ам	0-7 насны		0-15 насны		16-28 насны		0-34 насны	
		тоо	хувийн жин	тоо	хувийн жин	тоо	хувийн жин	тоо	хувийн жин
1.Алтанбулаг	3059	410	13.40	846	27.66	1716	56.10	1989	65.02
2.Аргалант	1764	204	11.56	433	24.55	977	55.39	1148	65.08
3.Архуст	1336	181	13.55	383	28.67	762	57.04	855	64.00
4.Батсүмбэр	6601	1004	15.21	1992	30.18	3647	55.25	4238	64.20
5.Баян	1984	310	15.63	612	30.85	1094	55.14	1309	65.98
6.Баяндэлгэр	1243	163	13.11	321	25.82	594	47.79	708	56.96
